Сангийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/105 дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2026 он

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Тендер шалгаруулалтын нэр:	Даланзадгад-Номгон чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ
Тендер шалгаруулалтын дугаар:	**ӨМАХААГ/20260103300**

2026 он

САНАМЖ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалтад заасан нээлттэй тендер шалгаруулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ жишиг баримт бичгийг баримтална. Мөн хуулийн 33 дугаар зүйлд зааснаар нээлттэй тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж буй тохиолдолд нэгдүгээр үе шатанд хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт заасан хүрээнд тус жишиг баримт бичигт зохих өөрчлөлтийг оруулан ашиглаж болно.

Энэ тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн санамж болон бүлэг, зүйлийн оноосон нэр нь зөвхөн уг баримт бичгийг ойлгоход хялбар болгох зорилготой.

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

Нэгдүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын зааварчилгаанд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэглэнэ.

II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Захиалагч нь оролцогч болон тендерт тавих шалгуур үзүүлэлт, мэдээллийг хоёрдугаар бүлэг дэх өгөгдлийн хүснэгтэд тусгана. Тендер шалгаруулалтын зааварчилгааны холбогдох зүйл, заалттай уялдуулан хаалт дотор налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг тусгаж өгөгдлийн хүснэгтийг боловсруулна.

III БҮЛЭГ.ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Захиалагч худалдан авах үйлчилгээний техникийн тодорхойлолт болон шаардлагатай бусад мэдээллийг энэ бүлэгт тусгана.

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Энэ бүлэгт тендерийг үнэлэхэд харгалзах шалгуур үзүүлэлтийг тусгана.

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Энэ бүлэгт сонирхогч этгээдээс тендер бэлтгэхэд шаардлагатай жишиг маягтууд багтана. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд үндэслэн жишиг маягтуудын хаалт дотор налуугаар бичсэн тохирох мэдээллийг зааварт нийцүүлэн бүрэн, үнэн зөв бөглөж ирүүлнэ.

VI БҮЛЭГ.ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Энэ бүлэгт заасан гэрээний нөхцөл нь гэрээний ерөнхий нөхцөл, гэрээний тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягтаас бүрдэнэ. Гэрээний ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулахгүйгээр хэрэглэх ба өөрчлөлт оруулах шаардлагатай бол гэрээний тусгай нөхцөлд өөрчлөлтийг тусгана. Захиалагч гэрээ байгуулах эрх олгосон оролцогч болон түүний ирүүлсэн тендерийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад тусгаж, гэрээ байгуулна.

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "**Хууль**" гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид "**үйлчилгээ**" гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна.

1.2. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгт болон зарлалд заана.

1.5. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол хуулийн 11.9-д зааснаар ажлын үр дүнд бий болох оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний нэр заасан этгээд эзэмшинэ.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан "Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам"-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид "цахим систем" гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20^1, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6.	**Сонирхогч этгээд, оролцогч**	6.1. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
		6.2. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.
		6.3. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
		6.4. Тендер шалгаруулалтад оролцох сонирхлоо илэрхийлэх аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т заасан үйлчилгээний хураамж төлсөн байна.
		6.5. ТШЗ-ны 6.4-т заасан үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.
7.	**Түншлэлийн болон туслан гүйцэтгүүлэх гэрээ**	7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.
		7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
		7.3. Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
		7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
		7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
		7.6. ТШЗ-ны 7.1-д заасан гэрээнд түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх үүрэг (тоо хэмжээ гэх мэт)-ийг үнийн дүнгийн хамт тодорхойлж, тусгасан байна.

Б.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

8.	**Тендер шалгаруулалтын баримт бичиг**	8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ: I.Тендер шалгаруулалтын зааварчилгаа; II.Өгөгдлийн хүснэгт; III.Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага; IV.Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт; V.Тендерийн жишиг маягт; VI.Гэрээний нөхцөл.
		8.2. Захиалагч шалгарсан оролцогчтой гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт

бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

8.3. Худалдан авах үйлчилгээний онцлогоос хамаарч гэрээний нөхцөлийг VI бүлэгт заасан гэрээний нөхцөлөөс өөрөөр тодорхойлох шаардлагатай бол үндэслэлийг дурдаж хуулийн 39.3-т заасанд нийцсэн худалдан авах гэрээний нөхцөлийг баримталж болно.

8.4. Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах

9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтийг хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар захиалагчид гаргах бол өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүргүүлнэ.

9.2. ТШЗ-ны 9.1-д заасан хүсэлтэд ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд болохыг нотлох баримтыг хавсаргана.

9.3. Тодруулгын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл захиалагч хуулийн 20.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах (эсхүл ажлын талбайтай танилцуулах) бол өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад ТШЗ-ны 6.4-т заасан сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй нь аж ахуй эрхлэгчийн тендер шалгаруулалтад оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

В.ТЕНДЕР БЭЛТГЭХ

11. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

11.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг оролцогч бэлтгэн ирүүлнэ.

11.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн ТШЗ-ны 11.1-д заасан хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

11.3. Тендер шалгаруулалтын баримт бичгийн хэл болон гадаад хэлээрх хувилбар хоорондоо зөрвөл ТШЗ-ны

11.1-д заасан хэлээр бэлтгэсэн тендер шалгаруулалтын баримт бичгийг баримтална.

11.4. Захиалагч ТШЗ-ны 11.1-д зааснаас өөр хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг тендер хянан үзэх, үнэлэхэд ашиглах ба оролцогч өөрөө орчуулсан, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

12. Тендерийн иж бүрдэл

12.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

12.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

12.2.1. ТШЗ-ны 13 дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

12.2.2. оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

12.2.3. өгөгдлийн хүснэгтэд зөвшөөрсөн бол ТШЗ-ны 14 дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

12.2.4. ТШЗ-ны 15 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

12.2.5. санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 16 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

12.2.6. үйлчилгээ үзүүлэх хуваарь;

12.2.7. оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19 дүгээр зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

12.2.8. ТШЗ-ны 20 дугаар зүйлд заасан үйлчилгээний үнийн задаргаа;

12.2.9. ТШЗ-ны 20.8-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

12.2.10. түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

12.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

12.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

13. Тендерийн жишиг маягтууд

13.1. Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх жишиг маягтаас аль шаардсан маягтыг дараах байдлаар ирүүлнэ.

13.1.1. Хуулийн 21.1.3-т заасны дагуу цахим системд үүсгэгдсэн бол цахим системээр ирүүлнэ;

13.1.2. ТШЗ-ны 13.1.1-д зааснаас бусад маягтыг тендерт хавсарган ирүүлнэ.

14. Хувилбарт санал

14.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан тохиолдолд оролцогч хуулийн 11.10-т заасанд нийцэх хувилбарт саналыг тендерт ирүүлж болно.

15. Ерөнхий шаардлагыг магадлахад шаардлагатай баримт бичиг

15.1. Оролцогч хуулийн 7.2-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 1-ийн дагуу ирүүлнэ.

15.2. Хэрэв өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 7.1-д заасан ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой баримт бичгийг ирүүлнэ.

15.3. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

15.3.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

15.3.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

15.3.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох нотлох болон ТШЗ-ны 15.2-т заасанд холбогдох баримт бичиг

15.4. Захиалагч оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 15.2, 15.3-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16. Санал болгож буй үйлчилгээ тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

16.1. Оролцогчийн санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг өгөгдлийн хүснэгтэд зааснаар ирүүлнэ.

16.2. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол оролцогч өөрийн санал болгож үйлчилгээний загвар, дээжийг тендер нээх эцсийн хугацаанаас өмнө захиалагчид хүргүүлэх ба шалгалт, туршилт хийх ажиллагаанд өгөгдлийн хүснэгтэд заасны дагуу оролцоно.

16.3. Нотлох баримт нь нийтлэл, зураг төсөл, зураг, үйлдвэрлэгчийн албан ёсны цахим хуудас зэрэг тухайн гүйцэтгүүлэх үйлчилгээний техникийн

тодорхойлолттой нийцсэн болохыг хянан үзэх боломжтой техникийн болон гүйцэтгэлийн бодит үзүүлэлтийг дурдсан баримт байж болно.

16.4. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

16.5. Захиалагчийн гүйцэтгүүлэх үйлчилгээг дагалдах бараа байгаа бол техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлох баримт бичиг ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 16.1-д зааж болно.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын талаар хангавал зохих доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд заах ба хуулийн 15 дугаар зүйлд заасныг баримтална.

17.2. Түншлэл нь ТШЗ-ны 17.1-д заасан доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг гишүүдийн тооноос үл хамааран хамтдаа бүрэн хангасан байна.

17.3. Борлуулалтын орлогын хэмжээ, ижил төстэй гэрээний үнийн дүнгийн шалгуур үзүүлэлтийг ТШЗ-ны 17.1-д зааснаар өгөгдлийн хүснэгтэд тусгасан бол түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн уг шалгуур үзүүлэлтийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.4. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана. Тухайн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нэг зөвшөөрөл, эсхүл гэрчилгээг захиалагч шаардсан бол түншлэлийн гишүүн тус бүр уг шаардлагыг хангасан байх шаардлагатай. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

17.6. Оролцогч, түүний түншлэлийн гишүүний хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээллийг тендерт ирүүлэхийг шаардах бол өгөгдлийн хүснэгтэд заана.

18. Санхүүгийн чадавхын шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

18.1. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан болон хуулийн 16.5-д хамаарах баримт бичгийн хүрээнд өгөгдлийн хүснэгтэд заана. Оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох санхүүгийн тайлангийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана.

18.2. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкнаас мэдэгдсэнээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад

асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.3. Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д заасан бол Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

19.1. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.2, 17.2.3, 17.2.4, 17.2.5-д заасан болон хуулийн 17.4-т хамаарах баримт бичгийн хүрээнд өгөгдлийн хүснэгтэд заана.

20. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

20.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

20.2. Үйлчилгээний үнийн задаргаанд техникийн тодорхойлолтод заасан үйлчилгээг нэг бүрчлэн тусгаж, тус бүрийн болон нийт үнийг тооцсон байна.

20.3. Оролцогч үнийн хөнгөлөлт санал болгох бол ТШЗ-ны 13-т заасан тендер илгээх маягтад заана.

20.4. ТШЗ 20.3-т зааснаар үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг тендерийн үнэ гэж үзнэ.

20.5. Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

20.6. Үйлчилгээний задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

20.7. ТШЗ-ны 20.2-т заасан үйлчилгээний үнийн задаргааны нийт үнэ нь арифметик алдаагүй боловч маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол үнийн задаргааны нийт нийлбэрийг тендер илгээх маягтын үнэ гэж үзнэ.

20.8. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг ирүүлнэ.

21. Тендерийн валют

21.1. Оролцогч Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

21.2. Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1-д заасан Монголбанкнаас олгосон зөвшөөрөлд үндэслэн ТШЗ-ны 21.1-д заасан тендерийн валютыг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

22. Тендер хүчинтэй байх хугацаа

22.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар тендер илгээх маягтад заана.

22.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 23-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

22.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь худалдан авах үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

23. Тендерийн баталгаа

23.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

23.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрээр ТШЗ-ны 23.1-д зааснаар ирүүлнэ.

23.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г.ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

24. Тендер баталгаажуулах, илгээх

24.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан цахим системд ирүүлэх ба тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ-ны 23-т зааснаар илгээнэ.

24.2. ТШЗ-ны 24.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

24.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 24.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх,

хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

24.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн Маягт 6-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

24.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 24.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

25. Тендер хүлээн авах эцсийн хугацаа, тендер нээх

25.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

25.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д.ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

26. Тендерийн талаар тодруулга авах

26.1. Тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

27. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

27.1. Тендерийг хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 12 дугаар зүйлд заасан иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулга, загвар, дээжид үндэслэн хянан үзнэ.

28. Тендерийн үнэлэх

28.1. Тендерийг хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу үнэлж, харьцуулна.

28.2. Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол тендер үнэлэх үндсэн шалгуур нь харьцуулах үнэ байна.

29. Арифметик алдааг залруулах

29.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

29.2. ТШЗ-ны 29.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

30. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

30.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

31. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

31.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг баримтална.

31.2. ТШЗ-ны 14.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол

	түүний хувилбарт саналыг үндсэн тендерийн нэгэн адил хянан үзэж, үнэлнэ.
	31.3. ТШЗ-ны 31.2-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
32. Тендерийн эрэмбэлэх	32.1. Тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
33. Оролцогчийн чадавхыг дахин магадлах	33.1. Багцтай тендер шалгаруулалтын хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг дахин магадална.
	33.2. ТШЗ-ны 33.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18 дугаар зүйлд заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19 дүгээр зүйлд заасан техникийн чадавх, туршлагын талаар шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
	33.3. ТШЗ-ны 33.2-т заасны дагуу оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

34. Шийдвэр хүргүүлэх	34.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэр гаргаж, цахим системд нийтэлснээр оролцогч нарт хүргүүлсэнд тооцно.
35. Гүйцэтгэлийн баталгаа	35.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
	35.2. Гүйцэтгэлийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
36. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах	36.1. Захиалагч ТШЗ-ны 8.2-т заасан гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
	36.2. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 36.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Санамж

Захиалагч гүйцэтгүүлэх үйлчилгээний онцлог шинж, оролцогчид тавигдах холбогдох хууль тогтоомж, түүний зарчимд нийцсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

Өгөгдлийн хүснэгтийг боловсруулахад дараах зүйлийг анхаарна. Үүнд:

1. Өгөгдлийн хүснэгт нь ТШЗ-ны зүйл, заалт болон түүнд хамаарах хэсгийг налуугаар бичсэн зааварт нийцүүлэн тохирох мэдээллийг нөхөх, гүйцээх зорилготой ба өгөгдлийн хүснэгтэд мөр нэмэхгүй, хасахгүй байх;
2. Оролцогчийн санхүүгийн болон техникийн чадавх, туршлагад тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буйг тогтоох зорилгоор шаардах баримт бичиг нь зөвхөн оролцогчийг тухайн үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэх гэрээний үүргийг гүйцэтгэх чадавх, туршлагатай болохыг нотлох баримт бичиг байна;
3. Оролцогч өөрийн тендерийн үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна. Иймд захиалагч хуулиар шаардсанаас бусад тохиолдолд тендерт хавсарган ирүүлэх баримт бичгийг нотариатаар гэрчлүүлэх, орчуулагчийн тэмдгээр баталгаажуулахыг оролцогчоос шаардахгүй;
4. Худалдан авах ажиллагааны цахим системтэй холбогдсон бусад мэдээллийн сангаас илгээсэн өгөгдлийг нотлох баримт бичгийг тендерт ирүүлэхийг шаардахгүй байх. Тухайлбал, Монгол Улсын хуулийн этгээдэд хамаарах улсын бүртгэлийн гэрчилгээ, авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагаа, санхүүгийн тайлан, татварын тодорхойлолт, дээд боловсролын дипломын тодорхойлолт гэх мэт болно.

Энэхүү санамж хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

II БҮЛЭГ.ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын нэр: Даланзадгад-Номгон чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлын техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ӨМАХААГ/20260103300
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Үгүй”
ТШЗ 1.4	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***“Үгүй”***
ТШЗ 1.5	Үйлчилгээний үр дүнд оюуны өмчийн эрхийг захиалагч, түүний этгээд эзэмших эсэх: Тийм
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Орон нутгийн төсөв
ТШЗ 2.1	Нийт төсөвт өртөг: 221,518,990 /хоёр зуун хорин нэгэн сая таван зуун арван найман мянга есөн зуун ер/ төгрөг
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах хүсэлтийг захиалагчид хүргүүлэх хаяг: Хүлээн авагчийн нэр: Худалдан авах ажиллагааны газар Хаяг: Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, 1 давхар, Худалдан авах ажиллагааны газрын 102 тоот өрөө Утасны дугаар: 7053-0209 Цахим шуудангийн хаяг: umnugovihudaldanavah@gmail.com Тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр албан бичгээр гаргаж, түүний хуулбарыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д нийтлэх бөгөөд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сохирхогч этгээдүүд дээрх цахим систем дэх тендерийн урилгын тодруулга, мэдээллийг байнга шалгахыг зөвлөж байна. Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 хоногийн өмнө ирүүлнэ.
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: ***“Үгүй”***
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	

ТШЗ 11.2	Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хувьд тендер шалгаруулалтын хэлийг ТШЗ 11.1-д зааснаас өөрөөр заах бол: “Монгол хэл”
ТШЗ 14.1	Хувилбарт санал ирүүлэхийг: ***“Зөвшөөрөхгүй”***
ТШЗ 15.2	Ерөнхий шаардлагыг магадлахтай холбоотой хуулийн 15.2-т зааснаас бусад нотлох баримт ирүүлэх эсэх: ***“Тийм”*** ТБОНӨХБАҮХАТХ 7.1. Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ: 7.1.1. төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах шийдвэр гарсан, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхэлсэн, бизнесийн үйл ажиллагааг зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эдгээртэй адилтгах нөхцөлд байгаа 7.1.2. Монгол улсын эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу өр төлбөр төлүүлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа, эсхүл татварын, эсхүл нийгмийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өртэй 7.1.3. өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасан харилцан хамааралтай этгээдийн оролцсон тендер шалгаруулалт, түүний багцад тендер ирүүлсэн 7.1.4. тухайн тендер шалгаруулалтад оролцохдоо бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл үнэ, бусад нөхцөл шалгуурыг урьдчилан тохиролцсон. 7.1.5. Энэ хуулийн 4.1.10-т заасан этгээд: 7.1.6. дараах этгээдийн аль нэг нь авлигын эсхүл мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон. 7.1.6.а. Оролцогч эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд 7.1.6.б. оролцогчийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасан эцсийн өмчлөгч 7.1.6.в. оролцогчийн Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан 7.1.7. Тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахад зөвлөгөө өгсөн, оролцсон, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, эсхүл тухайн зөвлөгөө өгсөн, оролцсон этгээдтэй харилцан хамааралтай 7.1.8. тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэсэн хугацаа дуусаагүй 7.1.9. энэ хуулийн 56.5.3, 56.5.4, 56.5.5-д заасан үндэслэлээр тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн эцсийн өмчлөгчийн үүсгэн байгуулсан эсхүл эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн хуулийн этгээд 7.2. Оролцогч энэ хуулийн 7.1-д заасан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг бичгээр гаргана. 7.3. Энэ хуулийн 7.1-д заасан нөхцөлийг магадлахтай холбоотой баримт бичиг ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бол

	оролцогч Монгол улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргуулан ирүүлнэ. 7.4. Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл баримт бичгийг энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.
ТШЗ 16.1	Техникийн тодорхойлолтод нийцсэнийг нотлоход шаардах баримт бичиг: ***"Шаардана"***
ТШЗ 16.2.	Тендер нээх эцсийн хугацаанаас өмнө загвар, дээж шаардах эсэх, шалгалт туршилт зохион байгуулах эсэх: ***"Үгүй"***
ТШЗ 17.1	Оролцогчид тавих санхүүгийн болон техникийн чадавх, туршлагын шаардлага: ***"Шаардлагатай"*** • Борлуулалтын орлогын хэмжээ: 2023, 2024 оны аль нэг жилийн борлуулалтын орлого нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувь болон түүнээс дээш байна. • Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Санал болгож байгаа үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна. • Ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байвал зохих жилийн тоо 2024, 2025 оны аль нэг жилд батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй үнийн дүнтэй тэнцэх ижил төстэй техник технологийн хяналт тавих зөвлөх ажлыг гүйцэтгэсэн байх.
ТШЗ 17.4	Зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ: ***"Шаардана"*** 5.2.4 Авто зам, замын байгууламжийг барих, засварлахад техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаанд хүчин төгөлдөр байвал зохино. Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь дээр дурдсан хугацааг хангаагүй буюу хүчингүй болсон тусгай зөвшөөрөл бүхий тендерээс татгалзана. Тендерт оролцогч, түншлэл, туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай бөгөөд тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс шалгах тул тусгай зөвшөөрлийн хуулбарыг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл нь үнэн зөв, бүрэн гүйцэт эсэхийг тендерт оролцогч нь нягтлах үүрэгтэйг анхаарна уу.
ТШЗ 17.6	Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: ***"Түншлэл зөвшөөрөхгүй"***
ТШЗ 17.7	Ижил төстэй давхар гэрээт ажил 3 аас их бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно. Урьд өмнө нь гэрээ байгуулсан, гүйцэтгэсэн зөвлөхийн ажил нь гэрээний үүргээ биелүүлээгүй, хугацаа хэтэрсэн болон ажил

<table>
<tr><td></td><td>гүйцэтгэх шатанд зургийн алдаа гаргасан зэрэг зөрчил үүссэн бол энэ сонгон шалгаруулалтад татгалзах үндэслэл болно.</td></tr>
<tr><td>ТШЗ 18.1</td><td>Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг шаардах эсэх: “Тийм”.

Тендерт оролцогчийн борлуулалтын орлогын мэдээллийг сангийн яамны санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн систем дэх санхүүгийн тайлангаас шалгана.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно. Үүнд:
• Байгууллагын харилцагч банк дахь харилцах дансны үлдэгдлийн баталгаа дансны хуулгыг харилцагч банкаар баталгаажуулж дансны үлдэгдлийг баталгааны хамт ирүүлсэн байна.
• Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий судлагдсан зээлийн тодорхойлолт ирүүлнэ.

Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдээс тендер шалгаруулалт зарласан өдрөөс хойш авсан, шалгах боломжтой QR код бүхий “Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг ирүүлнэ. Уг тодорхойлолтод төлөгдөж дуусаагүй зээлийн мэдээлэл “Хэвийн”-ээс бусад ангилалд байгаа тохиолдолд татгалзах үндэслэл болно. (“Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолт”-ыг www.sainscore.mn, www.burenscore.mn хаягаар хандан авна. Харилцагч банкны тодорхойлолтыг тендерийг үнэлэхэд харгалзан үзэхгүй.)

Харилцагч банк тус бүрээс хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн өргүй талаарх тодорхойлолтыг ирүүлнэ. Дээрх тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байна.

- Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2024, 2025 он тус бүрийн санхүүгийн тайланг өөрийн тендерт хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого, бусад шаардлагатай мэдээллийг авна.

2023, 2024 санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэгтэй оролцогчийн хувьд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг ирүүлнэ.</td></tr>
<tr><td>ТШЗ 19.1</td><td>Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэх эсэх: “Тийм”

Ижил төстэй ажилд тооцуулахаар ирүүлсэн ажлын гүйцэтгэсэн гэрээ, магадлалын дүгнэлтийн хуулбарыг ирүүлнэ. Аль нэг баримтыг ирүүлээгүй бол тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу.

Ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ.
<table>
<tr><td>№</td><td>Албан тушаал</td><td>Тоо</td><td>Мэргэжил, боловсрол</td><td>Ажилласан жил</td></tr>
<tr><td>1</td><td>Багийн ахлагч</td><td>1</td><td>Автозамын инженер</td><td>Мэргэжлээрээ 5-ээс доошгүй жил ажилласан</td></tr>
</table></td></tr>
</table>

2	Автозамын инженер	1	Автозамын инженер	Мэргэжлээрээ 3-ээс доошгүй жил ажилласан
3	Гүүр болон хиймэл байгууламжий н инженер	1	Гүүрийн инженер	Мэргэжлээрээ 3-ээс доошгүй жил ажилласан
4	Хиймэл байгууламжий н инженер	1	Автозам гүүрийн инженер	Зам барилгын ажилд 3 жил, үнээс 1 ээс доошгүй жил зам гүүрийн хяналтын инженерэр ажилласан байх
5	Хэмжилтийн инжегер	1	Геодизийн инженер	Туршлага 3 жил 1 жилд хяналтаар ажилласан байх
6	Материалын инженер	1	Материалын инженер	Тухайн мэргэжилээрээ 3 жил ажилласан байх

- ✓ Тухайн тендерт санал болгосон ерөнхий архитектор болон инженер нь давхар гэрээт олон ажилтай мөн захиалагч байгууллагаас зарлагдсан худалдан авах ажиллагааны зөвлөхийн сонгон шалгаруулалтад 3 аас дээш ажилд шалгарч гэрээ байгуулагдахаар шийдвэрлэгдсэн болон мэдэгдэл гарсан бол тус тендерээс татгалзах үндэслэл болно. /*мэргэжилтэй ажилтны нөөц чадамжаас хэтрүүлж олон гэрээт ажил авч гүйцэтгэх хүлээлгэж өгөх хугацаа, ажил удаашрах гэх мэт урьд өмнөх оны туршлагаас хамаарсан заалт болно*/

Дээрх инженер, техникийн ажилтнуудын жагсаалтыг маягтад заасны дагуу гаргаж, тухайн төсөл арга хэмжээнд ажиллуулахаар захирлын тушаалаар томилсон байх бөгөөд тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр гаргаж цахим системээр ирүүлнэ. Оролцогчийн үндсэн ажилтан хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг цахим систем дэх 5 бүлэг заасан маягтаар зааварчилгааны дагуу санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. Цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсний нийлүүлэгчийн гарын авлага хэсгээс зааварчилгаатай танилцана уу.

2. Зургийн ерөнхий инженер болон цахилгааны инженер нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн гурван сар тендерт оролцогч аж ахуйн нэгж тасралтгүй төлсөн болохыг цахим системээс шалгана.

Оролцогчийн санал болгосон ажилтны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тухайн оролцогч төлдөггүй ажилтны хувьд хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай.

3. Дээрх инженер, техникийн ажилтнуудын Сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ

	үү. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/ системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. https://bit.ly/3J1QmHZ . Даатгуулагчийн нийгмийн даатгал төлсөн тодорхойлолтыг төрийн мэдээллийн сангийн E-Mongolia.mn-аас татан авч хавсаргана /QR кодоор нь шалгана/.
ТШЗ 20.5.	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: ***“Тохируулахгүй тогтмол байна”***
ТШЗ 21.2	Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар, эсхүл захиалагч Монголбанкнаас зөвшөөрөл авснаар тендерийн валютыг ТШЗ-ны 21.1-д зааснаас өөрөөр заах бол: ***[төгрөг]***
ТШЗ 23.1	Тендерийн баталгаа: “**Шаардана** Тендерийн баталгааны дүн: Батлагдсан төсөвт өртгийн 0,5 хувь Хүчинтэй байх хугацаа: Гэрээ байгуулах хүртэл Тендерийн баталгааг тендерийн материалд хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд тендерийн баталгаа гаргагч арилжааны банкнаас цахим системээр тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн байна. Тендерийн баталгааг дараах тохиолдолд улсын орлого болгоно. Үүнд: ✓ Оролцогч тендерийг нээсний дараа тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерийн бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан. ✓ Гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх үүргээ хэрэгжүүлээгүй. ✓ Тендерт оролцогчийн гаргасан гомдлыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн. Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 4.6 дахь хэсэгт заасны дагуу Захиалагч тендерийн баталгааг хуулийн 20.6-д зааснаар «хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулсны дараа цахим системээр хүчингүй болгоно. Анхааруулга: Цахим тендерт оролцогч тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем цахим тендерийн баталгаа гаргагч эрх бүхий арилжааны банкны мэдээллийн сангаас тендерт оролцогчийн цахим тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана. Баталгааг цахимаар ирүүлээгүй нь энэ тендерээс татгалзах шалтгаан болно.
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 24.5.	Оролцогчдод ил болгох нэмэлт баримт бичгийн жагсаалт: 1.Тендерт ирүүлсэн төсвийн товчоо. 2. Ажил гүйцэтгэх хуваарь 3. Хүний нөөцийн жагсаалт...
ТШЗ 25.1.	Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

	Цаг: 11 цаг 00 минут Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.
ТШЗ 25.2.	Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна. Огноо: 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр Цаг: 11 цаг 45 минут Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, 1 давхар, Худалдан авах ажиллагааны газрын 102 тоот өрөө.
Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ	
ТШЗ 28.2.	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: [***"Үгүй"***]
ТШЗ 30.1	Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглах эсэх: ***["Ашиглахгүй"]***

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Санамж

Захиалагч болон үнэлгээний хороо нь худалдан авах үйлчилгээний техникийн тодорхойлолтыг боловсруулахад энэхүү санамжийг ашиглана.

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай үйлчилгээг нарийвчлан тодорхойлоход оршино. Уг санамж нь хэм хэмжээ тогтоохгүй ба захиалагчаас батлах тендер шалгаруулалтын баримт бичгийн хэсэг болохгүй.

- Ойлгомжтой сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.
- Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд худалдан авах үйлчилгээний шинж чанар, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийн үнэлгээ зөв хийгдэнэ.
- Техникийн тодорхойлолт боловсруулахдаа батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгавал зохино.
- Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Үйлчилгээг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.

Шалгалт, туршилт

[Захиалагч оролцогчоос санал болгож буй үйлчилгээтэй холбоотой шалгалт, туршилт хийсэн болохыг нотлох баримт, үүнтэй холбоотой мэдээлэл ирүүлэхийг шаардаж болно. Загвар, дээжийг хэрхэн шалгах, турших тухай тодорхой заана.]

[Үйлчилгээний даалгаврыг хавсаргана уу.]

Үйлчилгээ үзүүлэх хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-7 хүртэлх баганыг, оролцогч 8 дугаар баганыг бөглөнө]

№	Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Үйлчилгээ үзүүлэх газар	Үйлчилгээ үзүүлэх хугацаа	
						Үйлчилгээ хүлээн авах хугацаа	Гүйцэтгэгчийн санал болгох хугацаа ***(оролцогч энэ баганыг бөглөнө)***
1	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*	*8*
1	*[Үйлчилгээний нэрийг бичих]*	*[Үйлчилгээнд холбогдох шинж чанарыг бичих]*	*[нэгжийн тоо ширхгийг бичих]*	*[Хэмжих нэгжийг бичих]*	*[Нийслэл хотын хэмжээнд, орон нутгийн хэмжээнд гэх мэтээр бичих]*	*[Гэрээ байгуулснаас хойш үйлчилгээ үзүүлэх хугацаа бич.]*	*[7 дугаар баганад заасан хугацаанд багтаан гүйцэтгэхээр санал болгож буй хугацааг бичих]*
2							
3							

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга/тэмдэг]:

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

IV.1.“Ашиглалтын хугацааны өртөг” тендер үнэлэх үндсэн шалгуур

[Техникийн тодорхойлолтод заасан бараанд ашиглалтын хугацааны өртөг үнэлгээний үндсэн шалгуур байхаар заасан бол Сангийн сайдын батлсан “Бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх тендерийн ашиглалтын хугацааны өртөг тооцох аргачлал, заавар”-т нийцүүлэн боловсруулсан мэдээллийг энд тусгаж, бусад тендер үнэлэх үндсэн шалгуурыг тендер шалгаруулалтын баримт бичгээс хасна.]

IV.2.Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 30.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. *Үйлчилгээ дуусгах хугацаа:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих]***

Хэрэв “ашиглах” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд ***[хувь бичих]****–аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.*

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас ***[тоо бичих]****-аас илүү* ***[“сар”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих]*** *хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. *Байгаль орчинд нөлөөлөх байдал:* ***[“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих.]***

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр

хийсвэрээр нэмж үнэлнэ. ***[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

3. *Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт:* ***["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих.]***

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. ***[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТУУД

Санамж

Оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичгийн V бүлэг дэх жишиг маягтаас аль шаардсан маягтыг ирүүлнэ. Маягт ирүүлэхэд дараах зүйлийг анхаарна уу:

1. Хуулийн 21.1.3-т заасны дагуу цахим системд үүсгэгдсэн бол цахим системээр ирүүлнэ;
2. ТШЗ-ны 14.1.1-д заасны дагуу бусад маягтыг тендерт хавсарган ирүүлнэ.

<u>Маягтуудын жагсаалт:</u>

Маягт 1: Тендер илгээх маягт 24

Маягт 2: Үйлчилгээний үнийн задаргаа 26

Маягт 3: Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл 27

Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл ... 27

Маягт 5: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл 27

Маягт 6: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт 27

Маягт 7: Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэдээлэл 28

Маягт 8: Үйлчилгээ үзүүлэх ажилтны товч намтар (CV) 29

Маягт 1: Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай ***[оролцогчийн нэр]*** нь танай байгууллагаас зарласан ***[тендер шалгаруулалтын нэр, дугаар]*** тендер шалгаруулалтад ***[үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, доор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид "**тендер**" гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцохтой холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна. Үүнд:
   2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
   2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
   2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй;
   2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт ***["санал болгоно" эсхүл "санал болгохгүй" гэж бичих]***. ***[Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих]***.
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш ***[ажлын 30 ба түүнээс дээш өдрийн тоо]*** өдрийн хугацаанд хүчинтэй байна.[1]
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

---

[1] Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол "*5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.*" гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:
Хаяг:

Маягт 2: Үйлчилгээний үнийн задаргаа

№	Нэр төрөл	Үйлчилгээний талаарх тодорхойлолт	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4х6)	Үйлчилгээ үзүүлэхэд ногдох татвар, хураамж	Нэр төрөл бүрийн нийт нэгж үнэ (7+8)
1	*2*	*3*	*4*	*5*	*6*	*7*	*8*	*9*
2								
	Тендерийн нийт нэгж үнэ *(10)*							

Маягт 3: Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дуусан/

Маягт 4: Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5: Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) □Үндсэн гүйцэтгэгч □Түншлэлийн гишүүн □Туслан гүйцэтгэгч

Маягт 6: Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл, тайлбар
1.		
2.		
...		

Маягт 7: Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэдээлэл

Төсөлд хариуцах албан тушаал	Ажилтны овог нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 8: Үйлчилгээ үзүүлэх ажилтны товч намтар (CV)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил:_____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил:_____Иргэншил:_____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл:_____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

_____

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дараалаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

_____

Хэлний мэдлэг:

_____

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо:_____

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Санамж

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн үйлчилгээг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн үйлчилгээг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалт дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ;
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.
8. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай танилцаж, судалсан байх шаардлагатай болохыг анхаарна уу.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ.ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

1.1. Энэ гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл доор дурдсан утгыг агуулна:

1.1.1. “Үйлчилгээ” гэж техникийн тодорхойлолт (үйлчилгээний даалгавар, техникийн тодорхойлолт, гэх мэт)-д заасан үйлчилгээ, болон дагалдах барааг;

1.1.2. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.3. “Үйлчилгээ үзүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;

1.1.4. “Талууд” гэж Захиалагч болон Үйлчилгээ үзүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;

1.1.5. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;

1.1.6. “Үйлчилгээ үзүүлэх газар” гэж үйлчилгээг гүйцэтгэх, хүлээлгэн өгөх болон дагалдах бараа нийлүүлэх газрыг;

1.1.7. “Доголдол” гэж гүйцэтгэсэн үйлчилгээ, дагалдах барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;

1.1.8. “Баталгаат хугацаа” гэж гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгчийн үзүүлсэн үйлчилгээг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад илэрсэн доголдлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцах хугацааг;

1.1.9. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Үйлчилгээ үзүүлэгчид шаардлага гаргах Иргэний хуульд заасан хугацааг;

1.1.10. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;

1.1.11. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Үйлчилгээ үзүүлэгчээс томилогдсон этгээдийг;

1.1.12. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал“ гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын

улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Гэрээний тайлбар

1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:

1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.

1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.

1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.

1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.

1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ

Үйлчилгээ үзүүлэх

2.1 Үйлчилгээ үзүүлэгч нь техникийн тодорхойлолтод заасан үйлчилгээг үйл ажиллагааны хуваарь, ГТН-д заасан хугацаанд гүйцэтгэнэ.

2.2 Үйлчилгээ үзүүлэгч гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэхэд ажилтан, тоног төхөөрөмж, бараа, материал зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.

2.3 ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.

2.4 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн жишигт нийцүүлэн гүйцэтгэнэ.

2.5 Үйлчилгээ үзүүлэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.

2.6 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.

Үйлчилгээ үзүүлэх газар

2.7 Үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэх газрыг ГТН-д заана.

Үйлчилгээ эхлэх хугацаа

2.8 Үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд эхлүүлнэ.

Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа

2.9 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд Захиалагчид хүлээлгэн өгч акт үйлдэнэ.

2.10 Үйлчилгээ үзүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үйлчилгээ үзүүлэх хугацааг сунгуулах тухай хүсэлт гаргаж болно:

2.10.1 Захиалагч ГЕН-ийн 2.6-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.10.2 Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд үзүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.

2.11 Захиалагч ГЕН-ийн 2.10-т заасан нөхцөл бүрдсэн гэж үзвэл Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгана.

2.12 ГЕН-ийн 2.10.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Үйлчилгээ үзүүлэгч нотлох үүрэгтэй.

Тайлагнах үүрэг

2.13 Техникийн тодорхойлолтод үе шатны тайланг ирүүлэхээр заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь ГТН-д заасан хугацаанд Захиалагчид хүргүүлнэ.

Ажилтныг солих

2.14 Ажилтан нас барсан, тэтгэвэрт гарсан, хөдөлмөрийн чадвараа алдсан, гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажиллах боломжгүй болсон тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн ажилтантай адил, эсхүл илүү чадвар, туршлага бүхий хүнийг нэн даруй авч ажиллуулна.

2.15 ГЕН-ийн 2.14-т зааснаас бусад тохиолдолд ажилтны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй.

Барааг хүлээлгэн өгөх

2.16 Техникийн тодорхойлолтод зааснаар үйлчилгээг дагалдах бараа нийлүүлэхээр заасан бол Үйлчилгээ үзүүлэгч нь дагалдах барааг ГТН-д заасан нөхцөл, хугацаанд хүлээлгэн өгч, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

2.17 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээ, түүний дагалдах барааг хүлээлгэн өгснөөр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.

Даатгал

2.18 Үйлчилгээ үзүүлэгч нь ГТН-д заасан эрсдэлд хамаарах даатгалд өөрийн зардлаар даатгуулж даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчид ирүүлнэ.

2.19 Үйлчилгээ үзүүлэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол Захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Үйлчилгээ үзүүлэгчээс гаргуулна.

Гүйцэтгэлийн баталгаа

2.20 Хуулийн 42.1-д зааснаар Гүйцэтгэлийн баталгаа гаргах Үйлчилгээ үзүүлэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Үйлчилгээ үзүүлэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ.

2.21 Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:

2.21.1 Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;

2.21.2 Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;

2.21.3 Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.

2.22 Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Үйлчилгээ үзүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.

2.23 ГЕН-ийн 2.11-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Хүлээн авах

3.1 Захиалагч нь үйлчилгээг ГТН-д заасны дагуу хүлээн авч акт үйлдэнэ.

Шалгалт, туршилт

3.2 Үйлчилгээ, дагалдах үйлчилгээ нь тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч, эсхүл түүний төлөөлөгч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд үйлчилгээ, дагалдах бараа доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний доголдлыг арилгана.

3.5 Үйлчилгээг хүлээн авсан болон шалгалт туршилт хийсэн нь Захиалагчийн доголдолтой холбогдуулж шаардлага гаргах эрхийг хязгаарлахгүй.

3.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

3.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.

3.8 Гэрээний үнэд хуулийн 40.1.2-т заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

3.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

3.10 Үйлчилгээ үзүүлэгчийн хүсэлтээр Захиалагч үүрэг гүйцэтгэх хугацааг ГЕН-ийн 2.11-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.

3.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

3.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.13 ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.

3.14 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

3.15 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Үйлчилгээ үзүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.

Өмчлөх эрх

3.16 Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн бүх төлөвлөгөө, тайлан, болон бусад баримт бичиг нь Захиалагчийн өмч байна. Үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр баримт бичгийн хуулбарыг авч үлдэж болох бөгөөд энэ тохиолдолд ГТН-д заасан хязгаарлалтын хүрээнд ашиглаж болно.

3.17 Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 1.5-д заасан этгээдэд үйлчилгээний үр дүнд бий болох оюуны өмчийн эзэмших эрх хадгалагдана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Баталгаат хугацаа

4.1. Баталгаат хугацааг ГТН-д заана.

4.2. Баталгаат хугацааг ГТН-д заасан бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа заагаагүй бол үйлчилгээг хүлээн авснаас хойш Иргэний хуульд заасан хугацаанд Захиалагч гомдлын шаардлага гаргаж болно.

4.3. Захиалагч нь баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн доголдолтой үйлчилгээний доголдлыг арилгахыг шаардах эрхтэй.

Доголдлыг илрүүлэх, арилгах

4.4. Захиалагч үйлчилгээний гүйцэтгэлийг шалгаж илэрсэн доголдлын талаар Үйлчилгээ үзүүлэгчид мэдэгдэнэ.

4.5. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор, шалгалт, туршилт хийж болно.

4.6. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа, эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Үйлчилгээ үзүүлэгчид хүргүүлнэ.

4.7. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Үйлчилгээ үзүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.

4.8. Үйлчилгээ үзүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.

4.9. Захиалагчын гаргасан зардлыг Үйлчилгээ үзүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

4.10. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.

Алданги

4.11. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

4.12. Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээг ГТН-д заасан хугацаанд үзүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчний

4.13. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүсэж үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх

шинжтэй онцгой нөхцөл байдал

боломжгүй болсон бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ тухай Захиалагчид ердийн боломжит хугацаанд бичгээр мэдэгдэнэ.

4.14. Үйлчилгээ үзүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.

4.15. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

4.16. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Үйлчилгээ үзүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч ГЕН-ийн 2.10-т заасан хүсэлт гаргаж болно.

Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа

4.17. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.

4.18. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл

5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй:

5.1.1. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн дагуу мэдэгдэл хүлээн авч тогтоосон хугацаанд доголдлыг арилгаагүй;

5.1.2. Үйлчилгээ үзүүлэгчийн төлөх алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин хувь)-д хүрсэн;

5.1.3. Үйлчилгээ үзүүлэгч тендерт оролцох, бараа нийлүүлэх явцад авлигын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.

5.1.4. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;

5.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;

5.1.6. Үйлчилгээ үзүүлэгч нь ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн;

5.1.7. Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн.

Үйлчилгээ үзүүлэгч гэрээг цуцлах

5.2. Үйлчилгээ үзүүлэгч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй:

5.2.1. Захиалагч нь ГТН-д заасан хугацаанд төлбөр төлөөгүй;

5.2.2. Төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөр төлөөгүй;

5.2.3. Захиалагчийн төлөх алдангийн хэмжээ гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин хувь)-д хүрсэн.

5.3. Үйлчилгээ үзүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.

Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл	5.4.	ГЕН-ийн 5.1, 5.2-т заасан гэрээ цуцлах үндэслэл бүрдсэн тохиолдолд гэрээ цуцлах мэдэгдлийг нөгөө талд бичгээр өгнө.
	5.5.	Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.
	5.6.	Гэрээ цуцлагдсан тохиолдолд нөгөө талд учирсан хохирлыг үүрэг зөрчсөн тал Иргэний хуульд заасан журмын дагуу арилгана.

ЗУРГАА. БУСАД НӨХЦӨЛ

Төлөөлөгч	6.1.	Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
	6.2.	Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.
	6.3.	Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
	6.4.	Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
Туслан гүйцэтгэгч	6.5.	Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. Тендерт санал болгосноор туслан гүйцэтгэгчийг оролцуулах ба өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах бөгөөд өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3 дахь заалт хангагдсан байна.
	6.6.	Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Үйлчилгээ үзүүлэгч хариуцна.
Оюуны өмч	6.7.	Үйлчилгээг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Нууцлал	6.8.	Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нуцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
	6.9.	Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нуцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.
Мэдэгдэл	6.10.	Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

6.11. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.10-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

6.12. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

6.13. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

6.13.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

6.13.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

6.14. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

6.15. ГЕН-ийн 6.14-т заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

6.16. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:

6.16.1. ГЕН-ийн 2.11-д заасны дагуу хугацаа сунгагдсан;

6.16.2. үнийн тохируулга хийсэн.

6.17. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

6.18. ГЕН-ийн 6.16-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.

Маргаан шийдвэрлэх

6.19. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.20. Талууд зөвшилцөж шийдвэрлэж эс чадвал Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Бусад

6.21. Гэрээний хүчинтэй байх хугацаанд үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл, эсхүл гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусгавар болох нөхцөл бий болсон бол хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө энэ талаар Захиалагчид мэдэгдэж, гэрээний үүргийг зөвшөөрөл, гэрчилгээний хугацаа сунгасан шийдвэр гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх шийдвэрийг Захиалагч гаргаж болно.

6.22. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэрээ байгуулах албан тушаалтан энэ хуульд зааснаар нийтийн албан тушаалтны ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг бөглөсөн байна.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1.	Үйлчилгээ үзүүлэх хугацаа: Үйлчилгээ үзүүлэх хугацаа нэг хугацаа байгаа тохиолдолд хугацаа: ***[огноо бичих]*** Үйлчилгээг үе шаттай үзүүлэх бол үйлчилгээ үзүүлэх үе шатны хугацаа: ***[огноо бичих]***
ГЕН 2.7.	Үйлчилгээ үзүүлэх, дагалдах бараа нийлүүлэх газар**:** ***[Үйлчилгээ үзүүлэх газрын хаяг байршил гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй бичих]***
ГЕН 2.8.	Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа**:** ***[огноог бичих]***
ГЕН 2.9.	Ажил үйлчилгээг хүлээлгэн өгөх: Үйлчилгээг хүлээлгэн өгөх хугацаа: ***[огноо бичих]*** Үйлчилгээг хэсэгчилсэн байдлаар хүлээлгэн өгөх бол үе шатны хугацаа: ***[огноо бичих]***
ГЕН 2.13.	Үе шатны тайлан ирүүлэхээр тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан эсэх ***["Тийм", "Үгүй" аль нэгийг сонгох]*** ***["Тийм" гэсэн бол Тайлан ирүүлэх үе шатны хугацааг бичих]***
ГЕН 2.16.	Үйлчилгээг дагалдах бараа байгаа эсэх: ***["Тийм", "Үгүй" аль нэгийг сонгох]*** ***["Тийм" гэсэн бол дагалдах бараа нийлүүлэх нөхцөл, хугацааг бичих]***
ГЕН 2.18.	***[Үзүүлэх үйлчилгээний онцлогийг харгалзан гарч болох даатгалын эрсдэл байгаа бол энд тодорхойлж бичих]***
ГЕН 3.1.	Үйлчилгээг хүлээн авах нөхцөл, журам: ***[Үйлчилгээ хүлээн авах нөхцөл, журмыг бичих]***
ГЕН 3.8.	Үнийн тохируулга***: ["Хийнэ", "Хийхгүй" аль нэгийг сонгох]*** ***Хэрвээ тохируулга хийх бол үнийн тохируулга хийх аргачлалыг доор тусгана:*** ***[***Дараах аргачлалыг баримталж болно: *Ажиллах хүч болон үндсэн материалын үнийн өөрчлөлтийг тусгах зорилгоор гэрээний хэрэгжилтийн явцад гүйцэтгэгчид төлөх үнийг дараах томьёог ашиглан тохируулна:* $$\Delta \mathrm{P} = \mathrm{P}_0 \left(a + b\frac{L_1}{L_0} + c\frac{M_1}{M_0} \right) - \mathrm{P}_0$$ *Үүнд:* $\Delta \mathrm{P}$ *-гүйцэтгэгчид төлөх нэмэгдэл үнэ;* P_0 *-гэрээний үндсэн үнэ;* a *-гэрээний үнэд шингэсэн ашиг, захиргааны зардлын тогтмол дүн. Ихэнх тохиолдолд 5-15 хувийн хооронд хэлбэлздэг;* b *-гэрээний үнэд ажиллах хүчний эзлэх хувь;* c *-гэрээний үнэд материалын эзлэх хувь;* L_0 *-гарал үүслийн улсын холбогдох салбарын ажиллах хүчний өдрийн индекс;*

	L_1/L_0 *-гарал үүслийн улсад мөрдөгдөж буй холбогдох салбарын ажиллах хүчний суурь өдрийн индекс (L_0) болон үнэ тохируулах өдрийн индекс (L_1);* M_1/M_0 *-гарал үүслийн улсад мөрдөгдөж буй үндсэн түүхий эдийн суурь өдрийн индекс (M_0) болон үнэ тохируулах өдрийн индекс (M_1).* *Захиалагч a, b, c итгэлцүүрүүдийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана. Энэ гурван итгэлцүүрийн нийлбэр дүн аль ч тохиолдолд нэг (1) байна.* *Оролцогч индексийн эх үүсвэр болон суурь өдрийн индексийг өөрийн тендерт зааж өгнө.* *Суурь өдөр нь тендер шалгаруулалт зарласан өдөр байна.* *Үнэ тохируулах өдөр нь барааг тээвэрлэхээс [тоо бичих], эсхүл үйлчилгээ үзүүлж эхлэхээс долоо хоногийн өмнөх өдөр байна (үүнийг үйлдвэрлэх явцын дунд үе гэж ойлгоно.* *Гэрээний үнийн P_0 валют, ажиллах хүч болон материалын индекс нь гарал үүслийн улсын валютаас өөр байх тохиолдолд, гэрээний үнийн тохируулалт буруу хийгдэхээс урьдчилан сэргийлж, залруулах итгэлцүүрийг ашиглана. Залруулах итгэлцүүр нь тус хоёр валютын суурь өдөр болон үнэ тохируулах өдрийн ханшны харьцаа байна.* *Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд энэ дагуу тохируулга хийнэ. Индексийн дүнг тооцохдоо үнийн хэлбэлзлийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг энд харгалзсан гэж үзнэ.]*
ГЕН 3.9.	Төлбөр төлөх хугацаа: ***[он, сар, өдөр бичих]*** Төлбөрийг хэсэгчилсэн төлөх бол төлбөр төлөх үе шатны хугацаа: ***[он, сар, өдөр бичих]***
ГЕН 3.16.	Баримт бичиг ашиглах хүрээ: ***[Үйлчилгээ үзүүлэгчид үлдээсэн баримт бичгийн ашиглах хүрээг тодорхой бичих]***
ГЕН 4.1.	Баталгаат хугацаа: ***[Баталгаат хугацааг тоогоор бичих]***
ГЕН 4.11.	**Захиалагчийн төлөх алдангийн хувь:** Алдангийн хувь: ***[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]***
ГЕН 4.12.	**Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:** Алдангийн хувь: ***[хоног тутамд 0.5 хүртэл хувиар тогтоож бичих]***

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № ***[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***

..... хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэрийг бичих]*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **[үйлчилгээ үзүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид "гүйцэтгэгч" гэх) нь ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэ гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Үйлчилгээ" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь ***[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]*** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч ***[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]***-ийн харилцах ***[Банкны нэрийг бичих]*** банкны ***[дансны дугаар бичих]*** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Доор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
   - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   - 1.1. Гүйцэтгэгчийн тендер, холбогдох маягт;
   - 3.2. Гэрээний тусгай нөхцөл;
   - 3.3. Гэрээний ерөнхий нөхцөл;
   - 3.4. Гүйцэтгэлийн баталгаа;
   - 3.5. Техникийн тодорхойлолт;
   - 3.6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.

4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:

4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл:

Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл:

Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо:	***[Зарлал нийтлэх огноог бичих]***
Тендер шалгаруулалтын төрөл:	Үйлчилгээ
Тендер шалгаруулалтын нэр:	***[төсөл, арга хэмжээний батлагдсан нэрийг бичих]***
Тендер шалгаруулалтын дугаар:	***[цахим системд заасан тендер шалгаруулалтын дугаарыг бичих]***
Нийт төсөвт өртөг:	***[нийт төсөвт өртгийг бичих]***
Тендер шалгаруулалтын арга:	Нээлттэй

1. ***[Захиалагчийн нэрийг бүрэн, товчлохгүйгээр бичих]*** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.

2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: ***[Хэрвээ багцтай бол "Тийм", багцгүй бол "Үгүй"]***

   Багц № 1: багцын нэр,
   Багц № 2: багцын нэр...гэх мэт.

3. Тендерийг ***[тендер хүлээн авах огноо, цаг]***–аас өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг ***[огноо]****-ны өдрийн,* ***[цаг]***[2]*-т* нээнэ.

4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: ***["Зөвшөөрнө" эсхүл "Зөвшөөрөхгүй" гэдгийн аль нэгийг сонгоно уу]***

5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: ***["Эрхтэй" эсхүл "Эрхгүй" гэдгийн аль нэгийг сонгоно уу]***

6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.

7. Тендерийн баталгаа шаардах эсэх: ***["Тийм" эсхүл "Үгүй"]*** Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.

8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: ***["Тийм" эсхүл "Үгүй"]***

9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: ***["Тийм" эсхүл "Үгүй"]***

10. Сонирхогч этгээд цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

[Захиалагчийн хаяг, утас/цахим шуудангийн хаяг]

---

[2] Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусанаас хойш 1 цагийн дотор байна.